



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 555

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Олон улсын хөтөлбөрийн сургалттай, төрийн өмчийн “Шинэ эхлэл” лаборатори сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нийт 25,555,198.20 (хорин таван сая таван зуун тавин таван мянга нэг зуун ерэн найман төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Олон улсын хөтөлбөрийн сургалттай, төрийн өмчийн “Шинэ эхлэл” лаборатори сургуулийн захирал Л.Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002533

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн
33 дугаар тогтоолын хавсралт

Олон улсын хөтөлбөрийн сургалттай, төрийн өмчийн "Шинэ эхлэл" лаборатори үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
акталж, данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Хэмжээ	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Балансын		Хуримтлагдсан н элэгдэл	Үлдэгдэл өртөл
					нэг бүрийн үнэ	нийт үнэ		
1	Ёочин	ш	1	2012/01/01	353,288.30	353,288.30	353,288.30	-
2	Ятга	ш	1	2012/01/01	262,117.50	262,117.50	262,117.50	-
3	Оёдлын машин	ш	16	2012/01/01	177,600.00	2,841,600.00	2,841,600.00	-
4	Оёдлын машин	ш	5	2012/09/03	750,000.00	3,750,000.00	3,750,000.00	-
5	Оёдлын машин	ш	5	2012/09/03	755,000.00	3,775,000.00	3,775,000.00	-
6	Цахилгаан гитар /соло/	ш	2	2012/09/03	270,000.00	540,000.00	540,000.00	-
7	Цахилгаан гитар /ритм/	ш	1	2012/09/03	280,000.00	280,000.00	280,000.00	-
8	Цахилгаан гитар/басс/	ш	1	2012/09/03	330,000.00	330,000.00	330,000.00	-
9	Цахилгаан гитарын пидаль	ш	3	2012/09/03	130,000.00	390,000.00	390,000.00	-
10	Бөмбөр	ш	1	2012/09/03	1,200,000.00	1,200,000.00	1,200,000.00	-
11	Цан	ш	1	2012/09/03	235,800.00	235,800.00	235,800.00	-
12	Морин хуур	ш	1	2012/01/01	188,040.80	188,040.80	188,040.80	-
13	Шанз	ш	1	2012/01/01	250,720.80	250,720.80	250,720.80	-
14	Шанз	ш	1	2013/02/13	250,720.80	250,720.80	250,720.80	-
15	Ном	ш	1347			10,907,910.00	10,907,910.00	-
НИЙТ ДҮН			1540			25,555,198.20	25,555,198.20	
						(хорин таван сая таван зуун тавин таван мянга нэг зуун ерэн найман төгрөг хорин мөнгө)		